



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 08 сарын 16 өдөр

Дугаар А/587

Булган сум

### Газар өмчлөх эрх хүчингүй болгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.3 дэх хэсэг, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэн Очирбат овогтой Сайнзаяа (ГЮ77031161)-д 6-р баг Булган баг, 3 дугаар гудамж, 324 тоотод байршилтай 6308000400 нэгж талбарын дугаартай 360 мкв газрыг аймгийн Засаг даргын 2005 оны 86 дугаар захирамжаар өмчлүүлэх шийдвэр гарсан боловч О.Сайнзаяа нь өмчлөх эрхийг хүчингүй болгох хүсэлт гарган 2005 оны 03 дугаар сарын 24-ний өдөр газар эзэмшүүлэх гэрээгээр Д.Эрдэнэбилэг (ГЮ77052910)-т шилжүүлсэн тул аймгийн Засаг даргын 2005 оны 86 дугаар захирамжийн 283 мөрийн холбогдох хэсгийг хүчингүй болгосугай.

2. Дээрх зөрчлийг арилгаж, газар өмчлөлийн улсын бүртгэлд өөрчлөлт оруулах ажлыг зохион байгуулахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ

